



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ**

2023 оны 03 сарын 07 өдөр

Дугаар 74

Улаанбаатар хот

**Хариуцлага тооцох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг, хөдөлмөрийн тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.2.3 дахь хэсгүүдийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Засгийн газрын авто бааз” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Г.Чинзориг нь ажлын хариуцлага алдсан тул түүний албан тушаалын цалингийн хэмжээг хоёр сарын хугацаатай 20 хувиар бууруулсугай.

2.Захирал Г.Чинзоригийн албан тушаалын цалингийн хэмжээг 2 сарын хугацаагаар 20 хувиар бууруулан тооцож олгохыг Ерөнхий нягтлан бодогч (Т.Урантогос)-д үүрэг болгосугай.

3.“Засгийн газрын авто бааз” төрийн өмчит үйлдвэрийн газрын Ерөнхий нягтлан бодогч (Т.Урантогос)-д холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага тооцох арга хэмжээг авч, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт 2023 оны 03 дугаар сарын 27-ний өдрийн дотор хариуг ирүүлэхийг “Засгийн газрын авто бааз” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал (Г.Чинзориг)-д үүрэг болгосугай.

4.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг үйл ажиллагаандаа чанд мөрдөн ажиллахыг “Засгийн газрын авто бааз” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал (Г.Чинзориг)-д үүрэг болгосугай.

5.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

132001120  
6-т huraldaan.docx